



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/80

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


- 1. 2023 оны сумын Засаг даргын шагнал урамшуулалд хэрэглэгдэх “Жуух бичиг”-ийн хавтас худалдан авахад 900,000 (есөн зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.
- 2. Тус ажилд зарцуулагдах 900,000 (есөн зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.
- 3. Холбогдох ажлыг зохион байгуулж, санхүүгийн баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ), нярав (Б.Энхцэцэг) нарт, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын
2023 оны...-р сарын...-ны өдрийн
...дугаар захирамжийн хавсралт



ЖУУХ БИЧГИЙН ТӨСӨВ

2023.05.29

№	Нэр, төрөл	Тоо, ширхэг	Үнэ	Нийт үнэ
1	Шивээговь сумын Засаг даргын жуух хавтас	30ш	30.000	900,000
Нийт үнэ				900,000

ТӨСӨВ ГАРГАСАН:

НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН: *AC*

Б.АЛТАНСҮХ